



МОНГОЛ БАНКНЫ  
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2009 оны 12 сарын 21 өдөр

Дугаар 216

Улаанбаатар хот

Стратеги батлах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. "Төлбөр тооцооны төвийн дунд хугацааны (2010-2015 он) хөгжлийн стратеги"-ийг хавсралтаар баталсугай.

2. Шаардлагатай гэж үзвэл "Төлбөр тооцооны төвийн дунд хугацааны (2010-2015 он) хөгжлийн стратеги"-д нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэх ажлыг тухай бүр хийж байхыг Төлбөр тооцоо, бүртгэлийн газар (М.Амгалан)-г даалгасугай.

3. Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитын газар (Г.Тогтохбаатар)-г даалгасугай.



Л.ПҮРЭВДОРЖ



Төлбөр тооцоо төвийн дунд хугацааны (2010-2015 он) хөгжлийн  
стратеги

**ГАРЧИГ**

ХЭТИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ .....	4
НИЙТЛЭГ БОДЛОГО.....	4
ТӨЛБӨР ТООЦООНЫ ТӨВИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ТӨЛӨВ.....	5
Нээлттэй байдал.....	5
Хамтын ажиллагаа.....	5
Бизнесийн хөгжил дэвшил.....	5
Ашиг (алдагдал)-ын төлөвлөлт .....	6
ЦААШИД НЭВТРҮҮЛЭХ АЖЛУУД .....	7
ТТТ-ийг хувьчлах ажлын хүрээнд .....	7
Банк хоорондын төлбөр тооцоог дамжуулах, боловсруулах ажлын хүрээнд.....	7
Төлбөрийн картын клиринг нэвтрүүлэх ажлын хүрээнд.....	7
Сүлжээ, техник хангамжийн бодлогын хүрээнд .....	8
Банк дундын цахим гарын үсгийн баталгааны мэдээллийн үйлчилгээний хүрээнд.....	9
Харилцагчдын бүртгэлийн нэгдсэн сангийн үйлчилгээний хувьд .....	10
/Хүлээн авагч, илгээгчийн дансны дугаар зөв эсэхийг гүйлгээ хийх явцад шалгах/ .....	10
Бэлэн бус төлбөр тооцоог дэмжих бусад үйл ажиллагаа.....	10
ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖИЛ, АЖИЛТНУУДЫН НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН БОДЛОГО .....	10
Бүтэц, зохион байгуулалт .....	10
Сургалтын бодлогын хүрээнд .....	11
Ажилтнуудын нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд .....	12
ХАВСРАЛТ 1. ТТТ-ИЙН ДУНД ХУГАЦААНД НЭВТРҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	13
ХАВСРАЛТ 2. ТТТ-ИЙГ ХУВЬЧЛАХ АЖЛЫН УРЬДЧИЛСАН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	14
ХАВСРАЛТ 3. ТТТ-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН .....	15

## ХӨГЖЛИЙН СТРАТЕГИЙН ҮНДСЭН БАРИМТ БИЧИГ

Энэхүү стратегийн баримт бичгийг Олон улсын төлбөр тооцооны банкнаас /ОУТТБ/ гаргасан Үндэсний төлбөр тооцооны системийг хөгжүүлэх зөвлөмж, Австралийн Клирингийн төвийн дунд хугацааны хөгжлийн стратегийн туршлагад үндэслэж, Төлбөр тооцооны системд олон улсад нийтлэг мөрдөх үндсэн зарчмыг удирдлага болгон Төлбөр тооцооны төв (цаашид ТТТ гэх)-д тулгарч байгаа асуудал, банк хоорондын төлбөр тооцооны болон төлбөрийн системийн зах зээлийн өнөөгийн байдлыг тусган боловсруулав.

## ХЭТИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

ТТТ-ийн үндсэн зорилго нь эдийн засаг дахь мөнгөний эргэлтийг хурдасгах, эдийн засаг болон санхүүгийн салбарт хийгдэж буй төлбөр тооцоог тасралтгүй, найдвартай, шуурхай гүйцэтгэснээр санхүүгийн тогтвортой байдлыг хангах явдал юм.

ТТТ-ийн эрхэм зорилго нь төлбөр тооцоонд оролцогч талын хооронд мөнгөн хөрөнгийг солилцох үр ашигтай, найдвартай бүтцийг хөгжүүлэх, технологийн дэвшлийг ашиглан банк, санхүүгийн байгууллагад төлбөр тооцооны бүх төрлийн үйлчилгээг шуурхай хэлбэрээр хүргэж, улмаар бэлэн мөнгөний хэрэглээг багасгаж, бэлэн бус төлбөр тооцоог нийтийн хэрэглээ болгоход оршино.

ТТТ-ийн үндсэн зорилтыг хэрэгжүүлэхийн тулд дараахь үйл ажиллагааг тасралтгүй хийж гүйцэтгэнэ:

1. Төлбөр гүйцэтгэгч, хүлээн авагч талын хоорондын төлбөр тооцоог түргэн, шуурхай, найдвартай шилжүүлэх;
2. Банк хоорондын төлбөр тооцооны үйлчилгээг түргэн, шуурхай, найдвартайгаар шилжүүлэх боломжийг олгохын тулд техник технологийн дэвшлийг ашиглах;
3. Банкуудын нэвтрүүлж буй бэлэн бус төлбөр тооцооны шинэ хэрэгслийг банк хоорондын төлбөр тооцоонд ашиглахыг дэмжиж, улмаар бэлэн мөнгөний хэрэглээг багасгах;
4. Төлбөр тооцоотой холбоотойгоор үүсч болох эрсдэлийг хязгаарлах, бууруулах боломжийг бүрдүүлэх;
5. Харилцагчийн болон төлбөр тооцооны мэдээллийн нууцлалыг хангаж ажиллах.

## НИЙТЛЭГ БОДЛОГО

ТТТ нь банк хоорондын төлбөр тооцооны хүрээнд дараахь нийтлэг бодлогыг баримталж ажиллана. Үүнд:

1. “Санхүүгийн дундын сүлжээ”-ний банк хоорондын төлбөр тооцоо, картын гүйлгээний дамжуулалт, боловсруулалт зэрэг үйл ажиллагааг олон улсын стандартад нийцүүлэн иж бүрэн, цогцолбороор нь хөгжүүлэх;
2. Төлбөр тооцооны системийн эрсдэлийг хязгаарлах, бууруулах;
3. Үр дүнгийн тооцооллыг өдөрт нь нийлж, тохируулах ;
4. Нөөц төв, нөөц төхөөрөмжтэй байх;
5. Мэргэжлийн ажилтнуудыг мэргэшүүлэн ажиллуулах, хөгжүүлэх, сургах;
6. Нууцлал аюулгүй байдлыг хангах;
7. Гадаад, дотоод хамтын ажиллагааг өргөжүүлэх;
8. Нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн тэргүүний шилдэг орчин үеийн техник, технологи судалж нэвтрүүлэх;

9. Үр өгөөжтэй, үр ашигтай тогтолцоог бий болгох замаар өөрөө өөрийгөө санхүүжүүлэх;
10. Оролцогч байгууллагуудад тэгш эрх бүхий үйлчилгээ үзүүлэх;
11. Оролцогч байгууллагууд, олон нийтэд нээлттэй, ил тод байх;
12. Бодлого нь ирээдүй рүү чиглэсэн ойлгомжтой, цаг үеэ олсон байхад чиглүүлэх;

## ТӨЛБӨР ТООЦООНЫ ТӨВИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ТӨЛӨВ

ТТТ-д тулгарч буй гол асуудал нь нэг үйлчилгээнд төвлөрсөн, давуу эрхтэй нийлүүлэгч болж байгаа явдал юм. Энэхүү онцлог байдлын сөрөг талыг арилгах зорилгоор дараахь үндсэн зарчмыг ТТТ нь үйл ажиллагаандаа хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Нээлтэй байдал
2. Хамтын ажиллагаа
3. Бизнесийн хөгжил дэвшил
4. Ашиг (алдагдал)-ын төлөвлөлт

### Нээлтэй байдал

ТТТ нь өөрийн санхүүгийн, үйл ажиллагааны дэлгэрэнгүй мэдээлэл дээр тулгуурлан тайлан гаргах ёстой бөгөөд энэ нь оролцогч талуудад тус төвийн мэдээллийг улам ойртуулахад дөхөм болно. Мөн “Жилийн эцсийн санхүүгийн тайлан”-г нягтлан бодох бүртгэлийн журмын дагуу боловсруулж, банк, санхүүгийн байгууллагуудад хүргүүлдэг олон улсын практик стандартыг мөрдөж ажиллах шаардлагатай. ТТТ нь өнгөрсөн ба ирэх жилийг хамруулсан санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг бэлтгэх нь дараа жилийн хураамж тооцох, энэ үеийн санхүүгийн үйл ажиллагааг тайлагнах суурь болж өгнө. ТТТ-ийн удирдлага, ажилтнууд нь “бизнесийн нээлттэй” бодлогыг боловсруулан олон нийтэд тайлагнах үүрэгтэй бөгөөд бодлогын бичиг баримтыг оролцогч талууд, банкуудад хүргүүлнэ. Бодлогын бичиг баримт, тайланг төлбөр тооцоонд оролцогчдод ил тод ойлгомжтой байдлаар тогтмол мэдээлж байна.

### Хамтын ажиллагаа

ТТТ-ийн эрхэлж буй үйл ажиллагаа нь ТТТ, оролцогч талын хамтын ажиллагаан дээр суурилж байдаг. Иймд ТТТ нь шинэ үйлчилгээ нэвтрүүлэх, тодорхой хугацаанд гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг оролцогч талд танилцуулж, олонхиор хүлээн зөвшөөрсний үр дүнд гүйцэтгэх хэрэгтэй.

ТТТ-ийн эзэмшигч байгууллага<sup>1</sup> эсхүл Монголбанкны зөвшөөрлийн дагуу банк хоорондын төлбөр тооцоог хөгжүүлэхэд өөрийн үйл ажиллагаагаа өргөжүүлэх, шинэ дэвшилтэд технологи нэвтрүүлэх, олон улсын туршлага судлах, ижил төстэй технологи нэвтрүүлэгч дотоод, гадаад, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах хэрэгтэй юм. Энэхүү хамтын ажиллагаа нь харилцан ашигтай байх зарчим дээр тулгуурлана.

### Бизнесийн хөгжил дэвшил

ТТТ шинээр нэвтрүүлж буй үйлчилгээнд хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын хэмжээг харгалзан бодлогоо боловсруулах, зах зээлд мэдрэмжтэй хандах нь чухал юм.

ТТТ нь дараахь үйл ажиллагаанаас орлого олж, шимтгэлийг урьдчилан тооцоолох замаар орлогоо бүрдүүлнэ. Үүнд:

1. Банк хоорондын бага дүнтэй гүйлгээний төлбөр тооцоо
2. Банк хоорондын төлбөрийн картын клирингийн үйлчилгээ

<sup>1</sup> ТТТ-ийг хувьчилсны дараа түүний эзэмшил нь Монголбанкнаас хувийн хэвшил рүү шилжих магадлалтай.

3. “Санхүүгийн дундын сүлжээ”-ний үйлчилгээ
4. Банк дундын нөөц төвийн үйлчилгээ
5. Банк дундын цахим гарын үсгийн баталгааны мэдээллийн үйлчилгээ
6. Харилцагчдын бүртгэлийн нэгдсэн сангийн үйлчилгээ
7. Бэлэн бус төлбөр тооцоог дэмжих бусад үйл ажиллагаа

Дээрх үйл ажиллагааг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Хавсралт 1-ээс харна уу.

#### **Ашиг (алдагдал)-ын төлөвлөлт**

ТТТ-ийн ашгийн зохистой түвшинг Төлбөр тооцооны үндэсний зөвлөлөөс /ТТҮЗ/ тодорхойлж өгөх нь үйлчилгээнд давуу эрхийг эдэлж их хэмжээний ашиг /алдагдал/ олохоос урьдчилан сэргийлнэ.

ТТТ нь орлогоороо урсгал зардлаа нөхөх, нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн тэргүүний шилдэг орчин үеийн техник, технологи судалж нэвтрүүлэх зорилгоор сан байгуулахад хүрэлцэхүйц хэмжээний ашигтай ажиллах зарчмыг баримтлана. Уг санг байгуулахад програм, техник хангамж, сүлжээ, өгөгдлийн санг тасралтгүй, найдвартай ажиллах нөхцөл, хүний нөөцийн хөгжлийн бодлогыг цогцоор хэрэгжүүлж ажиллах шаардлага гарч байна. Урсгал зардал нь Олон улсын хөгжлийн агентлагт төлөх өр<sup>2</sup>, цалин, нэмэгдэл урамшуулал, техник тоног төхөөрөмжийн ашиглалт, элэгдэл хорогдол, сургалт, захиргаа, гишүүнчлэлийн хураамжийн зардлаас бүрдэнэ.

ТТТ нь жил бүрийн орлого, урсгал зардлаа Монголбанк, ТТҮЗ, харилцагч байгууллагад ил тод, нээлтэйгээр тайлагнаснаар харилцагчтай эрх тэгш, шударга, харилцан ажиллах боломжоор хангагдана.

Мөн ашиг, алдагдлын тооцооллыг жил бүрийн үйл ажиллагаандаа хийж, дараа жилийн зардлыг тооцохдоо урсгал нийт зардал, орлогын урьдчилсан төлөвлөгөө боловсруулж, үйлчилгээний шимтгэлийн хэмжээг ТТҮЗ-ийн зөвшөөрлийн дагуу Монголбанкаар батлуулна.

#### **ТӨЛБӨР ТООЦООНЫ ТӨВИЙН ӨМЧЛӨЛ**

ТТТ-ийн үйл ажиллагааны онцлог, түүний эдийн засгийн хөгжилд оруулах боломж зэрэгт Монголбанк, ТТҮЗ-өөс онцгой анхаарал тавин ажиллах ёстой. Аль нэг байгууллагын эрх ашгийн төлөө ажиллах, эсхүл ямарваа нэгэн байгууллагын давуу өмчлөлд байх нь үйл ажиллагаа, үзүүлэх үйлчилгээний найдвартай байдал, бизнесийн хөгжил дэвшилд сөргөөр нөлөөлнө.

Монголбанк нь ТТТ-ийг оновчтой шийдлээр хувьчилснаар банк, санхүүгийн байгууллагын хөрөнгө оруулалтыг татаж, тус төвийн үйл ажиллагааны үр өгөөжийг нэмэгдүүлэх юм.

Иймд, ТТТ-ийн хувьчлах зарчим, түүнд тавих хяналт, үйл ажиллагааг хүлээлгэн өгөх, хүний нөөцийн асуудал, ажлын байрны баталгаа, банк санхүүгийн байгууллагад үзүүлэх үйлчилгээ, ашиг, алдагдал зэргийг багтаасан хувьчлалын стратеги, төлөвлөгөө боловсруулж, Төрийн өмчийн хороо, ТТҮЗ болон мэргэжлийн бусад байгууллагаас санал авч хэрэгжүүлнэ. Тус төвийн хувьчлах ажлын урьдчилсан төлөвлөгөөг Хавсралт 2-оос харна уу.

---

<sup>2</sup> Монгол Улсын Засгийн газар, Дэлхийн банк хоорондын хөнгөлөлтэй зээлийн гэрээний дагуу Монголбанк 2002 оноос эхлэн төлбөрийн системийг шинэчлэх зорилгоор “Санхүүгийн чадавхийг хөгжүүлэх, төлбөрийн системийг шинэчлэх MOG3659” төслийн санхүүжилтээр ТТТ-ийг байгуулсан. Зээлийн гэрээний дүн 2.72 сая SDR, ТТТ-ийн зарцуулалт 3.7 сая ам доллар 2012 оны 11 дүгээр сараас 2042 оны 5 дугаар сар хүртэл төлбөр төлөх хуваарьтай.

ТТТ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө, ажлын тайлан, бодлогын бичиг баримтуудыг ТТҮЗ-д танилцуулан санал, зөвлөмжийг авч, ажиллах зарчим баримтлана. Энэ нь ТТТ-ийг хувьчлах нөхцлийг бүрдүүлэх үндэс болно.

ТТТ нь эрх зүйн орчин, сүлжээ, техник, програм хангамж, боловсон хүчний хувьд бүрэн бэхжиж, үйлчилгээний орлогоороо зарлагаа нөхөн ажиллах боломж бүрдсэн тохиолдолд тус төвийг хувьчлах асуудлыг холбогдох газруудад Монголбанк тавина.

ТТТ-ийг ТТҮЗ-ийн гишүүн байгууллагуудад хувьчилж, үйл ажиллагааг нь ХХК-ийн хэлбэрт оруулж ажиллууллахад Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооноос үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл авна.

ТТТ хувьчлагдсаны дараа эзэмшигч байгууллага нь үйлчилгээний шимтгэл, орлогын хэмжээг ТТҮЗ-тэй зөвшилцсөний дагуу тогтооно.

## **ЦААШИД НЭВТРҮҮЛЭХ АЖЛУУД**

### **ТТТ-ийг хувьчлах ажлын хүрээнд**

ТТТ нь банк хоорондын төлбөрийн картын клирингийн програм, техник хангамжийн туршилтын ажиллагааг бүрэн дуусгах, “Төлбөрийн картын журам”-ын дагуу шаардлагатай дүрэм, зөвлөмжүүдийг боловсруулах зэрэг ажлуудыг хийж, хэвийн тасралтгүй, найдвартай ажиллагааг ханган ажиллаж, орлогоороо зардлаа нөхөх зарчмыг дунд хугацаанд хэрэгжүүлнэ.

ТТТ-тэй ижил төстэй үйл ажиллагаа эрхэлдэг олон улсын байгууллагын хувьчлалтай холбоотой туршлагыг судлах, хувьчлалын аргачлал, стратеги, зарчмыг тодорхойлж, холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран шийдвэрлэнэ.

### **Банк хоорондын төлбөр тооцоог дамжуулах, боловсруулах ажлын хүрээнд**

ТТТ нь банк хоорондын бага дүнтэй төлбөр тооцоог тасралтгүй, найдвартай ажиллагаагаар хангаж ажиллах, онцгой байдлын үед банк хоорондын их дүнтэй төлбөр тооцооны нөөц төв болж шилжин ажиллах, мэдээллийн технологийн менежментын стандартуудыг нэвтрүүлэх, өөрийн үйл ажиллагаандаа жилд 1 удаа Монголбанкны ТТБГ-ын Төлбөрийн бодлого, зохицуулалтын алба (ТБЗА) эсхүл мэргэжлийн байгууллагаар хөндлөнгийн хяналт хийлгүүлнэ.

Түүнчлэн, ТТТ нь төлбөр тооцооны талаар олон улсын туршлага судалж, нэвтрүүлснээр олон улсад мөрдлөг болсон нийтлэг босго стандартын дагуу ажиллах, Төрөөс баримтлах мөнгөний бодлогыг дэмжиж, бэлэн бус төлбөр тооцоог нийтийн хүртээл болгон ажиллана.

### **Төлбөрийн картын клиринг нэвтрүүлэх ажлын хүрээнд**

Төлбөрийн картын клиринг нэвтрүүлснээр оролцогч талуудын ашиглалтын зардлыг бууруулж, картаар хийгдэх гүйлгээний тоо нэмэгдэнэ. Ингэснээр бэлэн мөнгөний урсгал банкууд руу чиглэх, карт эзэмшигчдийн тоо өсөх, картаар үйлчлэх байгууллагууд нэмэгдэх, банкууд картын бизнест бүтээгдэхүүн үйлчилгээ, менежментээрээ өрсөлдөнө. ТТТ нь эдгээр давуу талыг банкуудын удирдлагад танилцуулж, төлбөрийн картын клиринг нэвтрүүлэхийг дэмжин ажиллахыг уриалах юм.

ТТТ нь төлбөрийн картын клиринг нэвтрүүлэх зорилтын хүрээнд дараахь ажлыг хийнэ.  
Үүнд:

1. Хадгаламж, ХААН, ХХБ-тай холболт, туршилтын ажлыг одоогоор хийж байгаа тул банк тус бүрийн онцлогт нийцсэн ISO8583 стандартын мессэжийн битүүдийг хөрвүүлж зөрүүгүй болгох, “MagicWall” програм хангамжийг боловсруулж, туршилтын ажиллагааг 2010 оны 1 дүгээр улиралд, картын клирингийг 2010 онд багтаан дуусгах,

2. Картаар үйлчлэгч байгууллагуудад байрших ПОС төхөөрөмжид тавигдах шалгуур, тоо хэмжээтэй холбоотой стандарт, олон улсын жишиг судалгаа хийж банкуудад зөвлөмж өгөх;
3. ТТТ нь картын гүйлгээнд төлөх хүү, шимтгэлийн талаар холбогдох баримт, зардлын тооцоо, олон улсын жишгийг судалж, банкуудад мөрдөх зөвлөмж өгөх;
4. Банк дундын ПОС, АТМ, ПОБ зэрэг төхөөрөмжид програм хангамжийн баталгаажуулалт хийх эрх бүхий байгууллага болох. (Энэ нь банкууд карт эзэмшигч, харилцагчидад програм, техник хангамжийн талаас гэмтэл, буруу програмчлалгүй төхөөрөмжөөр үйлчилж байгаагийн баталгаа болж, иргэдийн банкуудад итгэх итгэлийг нэмэгдүүлнэ)
5. Чип карт (EMV) зэрэг олон улсын картын бизнест шинээр нэвтэрч буй бүтээгдэхүүн, технологийн дэвшилтэт талыг өөрийн улсад нэвтрүүлэн ажиллах, холбогдох стандартыг мөрдөн ажиллах зөвлөмжийг өгөх;
6. Дээрх үйлчилгээ, судалгаа, зөвлөмжийг банкуудад хүргэснээр клирингийн төвд тавьдаг үйлчилгээний болон технологи, хүний нөөцийн талаархи олон улсад нийтлэг мөрддөг шаардлагыг давж, өрсөлдөхүйц түвшинд хүрэх.


### Сүлжээ, техник хангамжийн бодлогын хүрээнд

“Санхүүгийн дундын сүлжээ” болох ажлыг үед шаттай хэрэгжүүлнэ. Уг сүлжээний найдвартай, тасралтгүй ажиллагааг хангах, техник технологийн дэвшилтэт хэлбэрийг ашиглах явдал нь ТТТ-ийн сүлжээ, техник хангамжийн нэн тэргүүний зорилго болно.

ТТТ-ийн үзүүлэх үйлчилгээний өртөг нь сүлжээ, техник хангамжийн ашиглаж буй технологи, түүний үр өгөөжөөс шууд хамаарах бөгөөд ТТТ нь хөгжүүлэх боломжтой платформ, технологи ашиглах бодлого баримтална. Үзүүлж буй үйлчилгээ, тэдгээрийн нууцлал, аюулгүй байдлыг хангах нь ТТТ-ийн онцгой үүрэг болно.

Тус төв нь одоогийн байдлаар сүлжээний хувьд оролцогч байгууллагуудтай үндсэн шугам буюу оптик кабелиар, нөөц шугам буюу диал-апаар холбогдон ажиллаж байна. Улаанбаатар хотоос 200 километр газарт байрлах Н1 нөөц төвийг ашиглахын зэрэгцээ Улаанбаатар хотод Н2 нөөц төвийг байгуулж оптик кабелиар үндсэн төвтэйгээ холбогдон ажиллаж байна. /Дүрслэл 1/

### Дүрслэл 1. Сүлжээний холболтын урсгал



ТТТ нь дунд хугацаанд сүлжээний бодлогын хувьд үндсэн 1, нөөц 2 төвтэйгээр үйл ажиллагаагаа тасралтгүй, найдвартай байдлаар үргэлжлүүлэн явуулах, шаардлагатай технологийн дэвшлийг нэвтрүүлэх бодлого баримтлан ажиллана.

Дээрх шаардлагуудыг хангах зорилгоор ТТТ нь олон улсын ISO-177799, ISO-27001 стандартад тулгуурласан сүлжээ, техник, технологи, нууцлал, аюулгүй байдлын цогц бодлого боловсруулж оролцогч байгууллагуудаас зөвшөөрөл аван мөрдөж ажиллана. Үүнд:

1. Ерөнхий үүрэг, хариуцлага
2. Мэдээллийн ангилал ба хяналт
3. Эрсдэлийн удирдлага
4. Хүний нөөц
5. Гадаад, дотоод орчны аюулгүй байдал
6. Мэдээллийн аюулгүй байдлын үйлчилгээ
7. Техник, програм хангамжийн аюулгүй байдал
8. Сүлжээ, түүний холболтууд
9. Систем, програм хангамж болон системийн боловсруулалт
10. Утасгүй сүлжээ
11. Тасралтгүй үйл ажиллагааны удирдлага

#### **Банк дундын нөөц төв болох ажлын хүрээнд**

Онцгой байдал, гэнэтийн аюул, байгалийн хүчин зүйлийн нөлөө гарах үед банкуудад тулгарах эрсдэлээс сэргийлэх үүднээс банкуудын өгөгдлийн сангийн мэдээллийг иж бүрнээр, хэсэгчлэн хадгалах, нөөцлөх байдлаар ТТТ нь банк дундын нөөц төв хэлбэрээр ажиллах бүрэн боломжтой юм. Энэхүү ажлын хүрээнд дараахь ажлуудыг төлөвлөөд байна. Үүнд:

1. Банк, санхүүгийн байгууллагуудад “Банк дундын нөөц төв”-д өгөгдлийн санг хэрхэн хадгалах, ажлын уялдаа холбооны талаар зөвлөмж боловсруулах;
2. Банкуудын өгөгдлийн сангийн мэдээллийг найдвартай, нууцлалын өндөр түвшинд хадгалах нөхцөл боломж, хүний нөөцөөр хангаж, сургаж ажиллах.

#### **Банк дундын цахим гарын үсгийн баталгааны мэдээллийн үйлчилгээний хүрээнд**

Цахим гарын үсгийн тухай хууль батлагдсаны дараа баримт бичгийн цахим хувилбар нь цаасан хувилбартай ижил эрх зүйн хүчин төгөлдөр болно. Энэ үед санхүүгийн гүйлгээ, мэдээ, тайлангийн цахим хэлбэрийг цахим гарын үсгээр баталгаажуулах үйл ажиллагааг оролцогч талтай холбоогүй, бие даасан гуравдагч этгээд явуулах шаардлагатай болно. Энэ үйл ажиллагааг ТТТ гүйцэтгэх нь зохимжтой юм. Энэхүү үйлчилгээг нэвтрүүлэхэд дараахь ажлыг зохион байгуулна.

1. Цахим гарын үсэг хадгалах, дамжуулах, нууцлалын олон улсын түлхүүр стандартыг судалж, хэрэгжүүлэн ажиллах;
2. Банк санхүүгийн байгууллагын цахим гарын үсгийн баталгааны мэдээллийн сантай болж, цахим төлбөр тооцоог электрон гарын үсгээр баталгаажуулах;
3. Цахим гарын үсгийн мэдээлэл хадгалах үндсэн, нөөц өгөгдлийн сантай байх.

### Харилцагчдын бүртгэлийн нэгдсэн сангийн үйлчилгээний хувьд

/Хүлээн авагч, илгээгчийн дансны дугаар зөв эсэхийг гүйлгээ хийх явцад шалгах/

Монгол Улсын төлбөр тооцоонд ашиглаж буй дансны дугаар, түүний эзэмшигчийн мэдээллийн сан байгуулж, лавлагааг цахим хэлбэрээр өгөх явдал нь бэлэн бус төлбөр тооцоог өргөжүүлэх, найдвартай явуулах, бэлэн бус төлбөр тооцооны шинэ үйлчилгээ нэвтрүүлэх ажилд эерэг нөлөөлөл үзүүлнэ. Энэхүү мэдээллийн сангийн техникийн ажиллагааг гүйцэтгэх, холбогдох лавлагааг цахим хэлбэрээр өгөх үйл ажиллагааг ТТТ дээр зохион байгуулж болно.

### Бэлэн бус төлбөр тооцоог дэмжих бусад үйл ажиллагаа

ТТТ нь цаашид сүлжээ, техникийн нөхцөл бололцоог ашиглан банк хоорондын цахим төлбөр тооцооны үйлчилгээг үзүүлэх боломжтой. Уг үйлчилгээ нь мэдээллийн технологийн хөгжилд суурилагдсан төлбөрийн хэрэгслээр нийтэд үйлчлэх цахим мөнгөний үйлчилгээ (банкны дансан дахь хөрөнгөө цахим төхөөрөмжөөр захиран, зарцуулах эрхийн үйлчилгээ, хадгалдаг, цэнэглэгддэг хэрэгслийг) болон цахим тоног төхөөрөмжөөр алсын хандалт (цахим төлбөрийн хэрэгслийг ашиглан банкны дансан дахь хөрөнгөө захиран зарцуулах боломжийг олгодог хэрэгсэл) ашиглан санхүүгийн болон санхүүгийн бус төлбөр тооцоог гүйлцэтгэх үйлчилгээг нэвтрүүлэн ажиллах боломжтой.

## ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖИЛ, АЖИЛТНУУДЫН НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН БОДЛОГО

### Бүтэц, зохион байгуулалт

ТТТ нь 2009 оны байдлаар нийт 14 ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

### Дүрслэл 2. ТТТ-ийн бүтэц, зохион байгуулалт



ТТТ нь дунд хугацааны хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх, ажилтнуудын боловсрол, мэдлэгийг нэмэгдүүлэх, ажиллах нөхцөл бололцоо, техник, тоног төхөөрөмжөөр хангах, нийгмийн хамгааллыг нэмэгдүүлэх замаар тэдгээрийг тогтвор, суурьшилтай, мэргэшүүлж, дадлагажуулан ажиллах, хүний нөөцийг бэхжүүлэх зорилго тавьж ажиллана.

Энэхүү стратегид төлөвлөсөн ажлыг хэрэгжүүлэхэд орон тоог нэмэх магадлалтай. ТТТ-ийн бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт, орон тооны өсөлт нь нэвтрүүлж буй шинэ үйлчилгээнээс хамаарахаас гадна энэхүү стратегийг тодорхойлогдсон нийтлэг бодлогод зохицсон байна.

### Сургалтын бодлогын хүрээнд

ТТТ-ийн дунд хугацааны хүний нөөцийн хөгжлийн бодлогод дараахь сургалтыг төлөвлөнө. Сургалтын төлөвлөгөө нь тус төвийн хүний нөөцийг бэхжүүлэх, мэргэжилтнүүдийг мэргэшүүлэхэд илүү анхаарч, ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжийг нэмэгдүүлнэ.

### Хүснэгт 1. Сургалтын чиглэл

Д/Д	Албан тушаал	Сургах чиглэл
1	Захирал	Мэдээллийн технологийн менежемент /ITIL/
		Төслийн удирдлага /Software project management/
2	Ашиглалтын менежер	Мэдээллийн технологийн менежемент
		Төлбөрийн системийн талаарх сургалт
		Төслийн удирдлага /Software project management/
3	Маркетингийн менежер	Төлбөрийн системийн талаарх сургалт
4	Өгөгдлийн сангийн зохицуулагч	Oracle 11g-гийн сургалт
		Үйлдлийн системийн сургалт
		Мэдээллийн технологийн чиглэлээр мэргэшүүлэх
		Мэдээллийн сангийн тохиргоо, оношлогооны сургалт
5	Системийн шинжээч	Мэдээллийн технологийн чиглэлээр мэргэшүүлэх
		Oracle 11g-гийн сургалт
		Төслийн удирдлага, Мэдээллийн технологийн аудит /Software project management /IT auditor/ Мэдээллийн технологийн менежемент /ITIL/
		Төлбөрийн системийн талаарх сургалт
		RHCE - үйлдлийн системийн сургалт
		Програм хангамжийн эрсдэлийн удирдлага /Software risk management/
		Програм хангамжийн туршилтын стратеги /Software testing management/
6	Ашиглалтын менежер	RHCE - ийн сургалт

		CCNA/CCNP-ийн сертификатын сургалт
		CEH-Certified ethical hacker
		ECSA/LPT EC-Council Certified Security Analyst
7	Оператор	Төлбөрийн системийн талаарх сургалт

### Ажилтнуудын нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд

2009 оны байдлаар ТТТ-ийн ажилтнуудын 35 хувь нь эмэгтэй, 64 хувь нь эрэгтэй, дундаж нас 28 байгаа нь цаашид тогтвор суурьшилтай ажиллах, хүний нөөцийг бэхжүүлэн ажиллах бүрэн боломжтой юм.

ТТТ-ийг хувьчлахад ажилтнуудын нийгмийн хамгааллыг баталгаатай байлгах зорилгоор дараахь бодлогыг баримтлана. Үүнд:

1. Төвийн ажилтнуудын хариуцан ажилладаг системийн мэдээллийн нууцлалын зэрэглэл өндөр ач холбогдолтой, сүлжээ, програм, техник хангамжийн хувьд нарийн бүтэцтэй, банк санхүү, бүртгэлийн мэдлэг илүү шаарддаг тул ажилтнуудын нийгмийн бодлогын асуудлыг хувьчлалын стратегид харгалзан үзэх.
2. Одоогийн ажиллаж буй хүний нөөцийг ажлын баталгаат байраар хангаж ажиллах чиглэлийг хөтөлбөрт тусгах.
3. Хүний нөөцийн 57% нь инженер техникийн ажилтнууд байгаа тул цалин, нөхөн олговор, урамшууллын системийг уян хатан болгож, банкуудын мэдээллийн технологийн ажилтнуудын цалингийн түвшинд ойртуулах, удаан хугацаанд тогтвортой ажиллах сонирхол бүрэлдүүлэх.
4. Банк хоорондын төлбөрийн картын клиринг нэвтрүүлэхэд ээлжийн операторууд, инженер техникийн ажилтнууд 24 цагийн хуваариар ажиллана. Иймд эдгээр ажилтнуудад шаардлагатай үед холбоо барих утас, системд яаралтай үед гэрээсээ болон бусад газраас нэвтрэн ажиллах интернэтийн гарц, ажиллах нөхцөлөөр хангах.

**ХАВСРАЛТ 1. ТТТ-ИЙН ДУНД ХУГАЦААНД НЭВТРҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	ТТТ-ийн дунд хугацаанд нэвтрүүлэх ажлууд	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он
1	Банк хоорондын бага дүнтэй гүйлгээний төлбөр тооцоог тасралтгүй, найдвартай явуулах	Тасралтгүй, найдвартай явуулах					
2	Банк хоорондын төлбөрийн картын клирингийн үйлчилгээ	Нэвтрүүлэх	Тасралтгүй, найдвартай явуулах				
3	“Санхүүгийн дундын сүлжээ”-ний үйлчилгээ	Тухай бүрт					
4	Банк дундын нөөц төвийн үйлчилгээ			Нэвтрүүлэх	Тасралтгүй, найдвартай явуулах		
5	Банк дундын цахим гарын үсгийн баталгааны мэдээллийн үйлчилгээ					Нэвтрүүлэх	
6	Харилцагчдын бүртгэлийн нэгдсэн сангийн үйлчилгээ			Нэвтрүүлэх	Тасралтгүй, найдвартай явуулах		
7	Бэлэн бус төлбөр тооцоог дэмжих бусад үйл ажиллагаа	Тухай бүрт					

**ХАВСРАЛТ 2. ТТТ-ИЙГ ХУВЬЧЛАХ АЖЛЫН УРЬДЧИЛСАН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	ТТТ-ийн хувьчлах урьдчилсан төлөвлөгөөт ажлууд	2010 он	2011 он	2012 он	2013 он
1	ТТТ-ийн хувьчлах зарчим, тавих хяналт, үйл ажиллагааг хүлээлгэн өгөх, хүний нөөцийн асуудал, ажлын байрны баталгаа, банк санхүүгийн байгууллагад үзүүлэх үйлчилгээ, ашиг ( алдагдал) зэргийг багтаасан хувьчлалын стратеги, төлөвлөгөө боловсруулах,				
2	Төрийн өмчийн хороо, мэргэжлийн бусад байгууллагаас санал авах				
3	ТТҮЗ-ийн гишүүн байгууллагуудад хувьчлах бэлтгэл ажлыг хийх				
4	ТТТ-ийг хувьчлах аргачлал, стратеги, зарчим, цаашид хэрхэн ажиллах төлөвлөгөөг Монголбанкны 33-өөр батлуулж, хувьчлах бэлтгэл ажлыг дуусгавар болгох.				
5	ТТТ-ийг хувьчилж, үйл ажиллагааг нь ХХК-ийн хэлбэрт оруулж, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрлийг авах.				

### ХАВСРАЛТ 3. ТТГ-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Монголбанкны ТТГ нь банк хоорондын бага дүнтэй гүйлгээг дамжуулан, боловсруулж, хуваарилах үйл ажиллагааг явуулдаг.

Одоогийн байдлаар тус төв нь нийт 16 банкны төв, СЯ-ны Төрийн сангийн газар, Монголбанкны төвтэй үндсэн шугам болох шилэн кабель, нөөц шугам болох физик кабелиар холбогдог бөгөөд холболт хэвийн ажиллаж байна. “Санхүүгийн дундын сүлжээ”-г найдвартай ажиллуулах зорилгоор байгуулсан үйлчилгээний гэрээнүүдэд өдөр тутмын хяналт тавин ажиллаж байна. Тус төвийн орлого, зардал дараахь байдалтай байна.

#### Хүснэгт 2. ТТГ-ийн орлого, зардлын тайлан

/2006-2010 он/

/сая төгрөгөөр/

Д/ Д	Орлого, зардлын төрөл	Дансны агуулга	2006 он	2007 он	2008 он	2009.12.21	2010 оны төсөв
<b>I. ОРЛОГО</b>							
1	Үйл ажиллагааны орлого	Бага дүнтэй шимтгэл	202,8	226,7	277,6	292,2	315,0
2	Картын удирдлагын систем болон бусад (Монгол шуудан, Хадгаламж банк, МОСТ ХХК-ийн түрээсийн төлбөр)			2,39	4,32	4,12	6,66
Нийт орлогын дүн			202,8	229,1	281,9	296,3	321,6
<b>II. ЗАРДАЛ</b>							
1	Цалин	цалин, нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгал	35,2	42,6	49,3	68,6	93,6
2	Харилцаа холбооны зардал	харилцаа холбоо	30,8	26,0	28,1	30,5	40,0
3	Хуримтлагдсан элэгдлийн зардал	элэгдэл	129,5	154,9	153,2	113,8	160,0

4	Гишүүнчлэлийн хураамж				105,0	128,6	178,1
7	Автоматжуулалтын зардал	автоматжуулалт	2,3	1,5	2,6	1,5	5,0
8	Зарлал сурталчилгааны зардал		-	0,9	-	-	2,8
9	Захиргааны зардал	албан томилолт, зочин төлөөлөгч	0,9	0,3	1,6	0,6	5,0
10	Удирдлагын зардал	ашиглалт, бичиг хэрэг, тээвэр шатахуун, хөдөлмөр хамгаалал, үндсэн хөрөнгийн засвар	11,9	11,4	14,2	15,7	24,8
11	Ажилчдын нөхөн олговрын зардал	нөхөн олговор	11,3	9,7	14,4	16,7	26,6
12	Сургалтын зардал	Сургалт	-		1,2	-	10,0
13	Бусад зардал	Бусад	13,6		0,1	1,0	1,5
<b>Нийт зардлын дүн</b>			<b>235,8</b>	<b>247,6</b>	<b>370,0</b>	<b>377,4</b>	<b>547,7</b>


### ТГТ-ийн орлого

Хүснэгт 2-оос харахад бага дүнтэй гүйлгээний шимтгэлийн орлого 2006 онд 202,8 сая төгрөг байсан бол 2009 оны 12 дугаар сарын байдлаар 292,2 сая төгрөгт хүрч, 90 сая төгрөг буюу 45%-иар өссөн байна.

**Дүрслэл 3. ГТТ-ийн орлого, зардлын дүн**

/2006-2010 он/

/сая төгрөгөөр/



Тус төвийн орлого ийнхүү жилээс жилд өсөн нэмэгдэхэд нөлөөлж буй гол хүчин зүйл нь банк хоорондын бага дүнтэй гүйлгээний өсөлт юм.

**Хүснэгт 3. Гүйлгээний тоо**

/2006-2010 он/

/сая ширхэгээр/

Д/Д	Банкны нэр	2006 он	2007 он	2008 он	2009.12 сар	2009 /ХБГ <sup>3</sup> /	2010 он
<b>НИЙТ:</b> /төгрөгөөр/		<b>1,3</b>	<b>1,5</b>	<b>1,8</b>	<b>1,9</b>	<b>2,2</b>	<b>2,4</b>


Хүснэгт 3–аас харахад банк хоорондын бага дүнтэй гүйлгээний тоо 2010 онд өмнөх оныхоос 0.5 сая ширхэгээр нэмэгдэх урьдчилсан тооцоолол гарч байна.

<sup>3</sup> ХБГ гэж Хүлээгдэж буй гүйцэтгэл

#### Дүрслэл 4 .Бага дүнтэй гүйлгээний тоо

/2006-2010 он/

/ сая ширхэгээр/



2006 оноос 2009 оны хооронд банк хоорондын бага дүнтэй гүйлгээний нийт тооны дундаж өсөлт 20%-тай байна.

2010 оны гүйлгээний тоог 2009 оны гүйлгээний тооны өсөлт дээр үндэслэн банк тус бүрээр тооцоолоход зарим банкуудын гүйлгээний тоо буурсан үзүүлэлттэй байсан боловч 2010 онд нийт гүйлгээний тооны өсөлт 10% байхаар тооцоолж байна.


Энэ таамаглалаар 2010 онд банк хоорондын бага дүнтэй гүйлгээний тоо 2,35 сая ширхэгт хүрэх хандлагатай байна.

ТТТ-ийн орлогын эх үүсвэр нь банк хоорондын бага дүнтэй гүйлгээний шимтгэл бөгөөд бусад байгууллагуудтай байгуулсан гэрээний дагуу серверийн өрөөний түрээс, шилэн кабелийн түрээс гэсэн бусад эх үүсвэрээс орлого орж байна.

#### ТТТ-ийн зардал

Хүснэгт 2-оос харахад ТТТ-ийн нийт зардал 2006 онд 235,8 сая төгрөг байсан бол 2009 оны 12 дугаар сарын байдлаар 377,4 сая төгрөгт хүрч 141,6 сая төгрөг буюу 60%-иар өссөн үзүүлэлттэй байна. Энэ өсөлтөд нөлөөлсөн гол хүчин зүйл нь мэргэжлийн байгууллагын гишүүнчлэлийн хураамж юм. ТТТ нь 2008 оноос эхлэн “Бевертек” компанитай байгуулсан “Програм хангамж, техникийн үйлчилгээний гэрээ”-ний дагуу 90 мянган ам.долларыг жил бүр төлөх болсон. Мөн цалингийн зардал дээрх хугацаанд 2 дахин өссөнтэй холбоотой юм.

**Дүрслэл 5. ТГТ-ийн зардлын бүтэц**



ТГТ-ийн зардлын бүтцийг 2009 оны байдлаар авч үзвэл нийт зардлын 34%-ийг гишүүнчлэлийн хураамж, 30%-ийг хуримтлагдсан элэгдэл, 18%-ийг цалингийн зардал эзэлж байна. Хуримтлагдсан элэгдэл ийнхүү өндөр хувь эзэлж байгаа нь тус төвийн үндсэн хөрөнгө, програм хангамжийн өртөг өндөр байгаатай холбоотой.

ТГТ-ийн нийт хөрөнгийн байдлыг авч үзвэл: /Хүснэгт 4/ нийт 2,3 тэрбум төгрөгийн анхны өртөг, 688 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий үндсэн хөрөнгөтэй. /2009 оны 10 дугаар сарын байдлаар/

**Хүснэгт 4. ТГТ-ийн нийт үндсэн хөрөнгийн өртөг**

/сая төгрөгөөр/

Анхны үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
2,322,7	688,5	1,634,1

Тус төв нь дараахь орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

1. Захирал – 1
2. Ашиглалтын менежер – 1
3. Маркетингийн менежер – 1
4. Ашиглалтын инженер - 3
5. Системийн шинжээч – 3
6. Оператор – 5

**ТТТ-ийн үйл ажиллагааны тайлан**

ТТТ-ийн 2006 оноос 2009 онуудын үйл ажиллагааны нэгдсэн тайланг авч үзвэл 2007 онд нийт 18,5 сая төгрөгийн, 2008 онд 88,0 сая төгрөгийн, 2009 оны 12 дугаар сарын байдлаар 81,0 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна. /Хүснэгт 5/

**Хүснэгт 5. ТТТ-ийн ашиг, алдагдал**

/2006-2010 он/

/сая төгрөгөөр/

Орлого, зардал	2006 он	2007 он	2008 он	2009 он	2010 он
Нийт орлого	202,8	229,1	281,9	317,2	388,4
Нийт зардал	235,8	247,6	370,0	425,0	550,2
<b>Үйл ажиллагааны ашиг/ алдагдал</b>	<b>-33,0</b>	<b>-18,5</b>	<b>-88,0</b>	<b>-81,0</b>	<b>-187,8</b>

2010 оны төсвөөр тус төвийн нийт зардал 550 сая төгрөг болж, 187 сая төгрөгийн алдагдалтай ажиллах тооцоо гарч байна. 2010 онд ТТТ нь хуучин серверээ акталж, хуримтлагдсан элэгдлийн зардлыг 28 сая төгрөгөөр бууруулахаар тооцоолж байгаа боловч, гишүүнчлэлийн хураамжийн гэрээний өөрчлөлт, бусад зардлын өсөлттэй холбоотойгоор зардал нэмэгдэнэ.

Үүнээс үзэхэд одоогийн мөрдөж буй банк хоорондын бага дүнтэй гүйлгээний шимтгэлийн хэмжээ оновчгүй тогтоогдсон байна гэсэн дүгнэлтэнд хүрч болохоор байгаа юм. ТТТ 2006 оноос хойш банк хоорондын бага дүнтэй нэгж гүйлгээний шимтгэлийг тогтмол 150 төгрөгөөр тогтоосон.

**Хүснэгт 6. Нэгж гүйлгээний өртөг**

д/д	Үзүүлэлт	2007 он	2008 он	2009 он	2010 он
1	Нэгж гүйлгээний өртөг	164	201	194	233
2	Гүйлгээний тооны өсөлт	17%	22%	16%	10%

Нийт зардлыг нийт гүйлгээний тоонд харьцуулж нэгж гүйлгээний өртгийг тооцоолоход 2007 оны байдлаар нэг гүйлгээ бүрийг 163.79 төгрөгөөр дамжуулж байсан бол 2008 онд 194 төгрөг, 2009 онд 201 төгрөг болсон байна. Энэ нь 2009 оноос 2007 онд дунджаар 22 төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Тус төвийн үйл ажиллагааны алдагдал ийнхүү өсч, улмаар нэгж гүйлгээний өртөг нэмэгдэж байгаа нь нэг талаас ТТТ-ийн тогтмол зардал өссөн, нөгөө талаас банк хоорондын бага дүнтэй гүйлгээний шимтгэл доогуур тогтоогдож байгаатай холбоотой бөгөөд алдагдлаа нөхөх зайлшгүй шаардлага гарч байна.

Монголбанк 2009-2010 онд санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, хямралын эсрэг авах арга хэмжээний хүрээнд “банк хоорондын бага дүнтэй гүйлгээний шимтгэлийг нэмэгдүүлэх шаардлагагүй” гэсэн шийдвэр гаргаад байна. Иймээс 2010 онд банк хоорондын бага дүнтэй гүйлгээнээс авах шимтгэлийг 150 төгрөг буюу хэвээр нь тогтоогоод байна.

Монголбанк 2006 оноос хойш банкууд, СЯ-ны Төрийн сангийн газарт гүйлгээний шимтгэлээс жилд 33-81 сая төгрөгийн хөнгөлөлт үзүүлсэн тооцоо гарч байна. 2010 онд урьдчилсан байдлаар 160 сая төгрөгийн /элэгдэл 28 сая төгрөгөөр буурна гэж үзвэл/ хөнгөлөлт банкууд болон СЯ-ны Төрийн сангийн газарт үзүүлэх урьдчилсан тооцоо гарч байна.

Энэ нь картын төлбөр тооцоо, клирингийг хөхүүлэн дэмжих, төлбөр тооцооны зардлыг жижиг харилцагчдад үүрүүлэхгүй байх зорилгод нийцэж байна. Эдийн засгийн сэргэлт, санхүүгийн салбарын тогтвортой байдал хангагдах хэрээр үйлчилгээний шимтгэлийн зардлыг нөхөхүйц хэмжээнд үе шаттайгаар нэмэгдүүлэн тогтооох шаардлага ирээдүйд гарах болно.

ТТТ-ийн зардал, банк хоорондын гүйлгээний тоо түүний өсөлтийн хэтийн төлөв, олон улсын жишиг зэргийг тооцож, банк хоорондын гүйлгээний шимтгэлийг хамгийн оновчтой хэлбэрээр тооцох аргачлалыг боловсруулахаар судалгаа хийж байна.